

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025

ГАРААНЫ ҮНЭЛГЭЭ НИЙГМИЙН УХААН Хувилбар С

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавартай нийт 80 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй.

Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай. Амжилт хүсье.

1. Тодорхой зорилго, түүнд хүрэх арга хэрэгсэл агуулга бүхий албан ёсны хөтөлбөрөөр хүүхдийн нийгэмшилтэд хувь нэмэр оруулахаар зорьж ажилладаг агент аль нь вэ?

Зөв хариултыг сонгоно уу. /1 оноо/

A. Гэр бүл B. Сургууль C. Үе тэнгийнхэн

D. Хэвлэл мэдээлэл E. Ажлын байр

2. Хүний нийгэмшилтийн талаарх ойлголтуудыг өгөгдөлтэй нь зөв харгалзуулна уу? /2 оноо/

a	Дахин нийгэмшилт	1	Шинэ байр суурь, үүргийн шаардлага, хүлээлтийг хүлээн авах, арга барил эзэмших, туршлага хуримтлуулах
b	Насанд хүрэгчид	2	Хөгжих гэхээсээ бие, сэтгэхүйн чадамж буурсантайгаа зохицох, даван туулах
c	Ахмад настан	3	Итгэж байсан зүйлээсээ ухарч, хатуу ширүүн дэг журамд зохицон өөрийгөө хүлээн авах дүр зургаа өөрчлөх гарцаагүй нөхцөлд орох
d	Хүүхэд нас	4	Ойр дотныхонтойгоо харилцах, дуурайх, дүрд тоглох багаар тоглох зэргээр хөгждөг

A. a3, b1, c4 d2

B. a2, b4 c1, d3

C. a4, b1, c2 d3

D. a3, b1, c2, d4

E. a2, b3, c4 d1

3. Шинэ үзэл санаа дэлгэрүүлэгчдэд тухайн цаг үед нь ноёрхогчдын зүгээс ямагт дайсагнасан, үл тоож ханддаг ч, нийгэмд өөрчлөлтийг эхлүүлдэг. Жишээ нь, XX зууны эхэн үед сонгуульд оролцож саналаа өгөхийн төлөө тэмцэж байсан эмэгтэйчүүдийг дорд үзэж, улмаар хорьж шийтгэж байжээ...

Ийнхүү ноёрхогч хэм хэмжээг хэн нэгэн хүн, хэсэг бүлэг хүмүүс эр зориг, тууштай тэмцлээрээ зөрчсөний үр дүнд өөрчлөлтийг авчирдаг. Энэхүү жишээ ямар ойлголтыг илэрхийлж байна вэ?

/2 оноо/

A. Гажуудлын харьцангуй мөн чанар B. Гажуудлын сөрөг үр дагавар

C. Гажуудлын эерэг үр дагавар D. Гажуудлын ил чиг үүрэг E. Гажуудлын сөрөг чиг үүрэг

4. Уг онолын хандлага нь хувь хүн утга учир, санаа зорилготойгоор бүтээлчээр үйлддэг хэмээн үзээд, хүн тодорхой зүйлд хандан үйлдэл хийхдээ тухайн зүйл нь юу болохыг өөрөө хэрхэн ойлгож, төсөөлж байгаадаа тулгуурладаг гэж үздэг онол аль нь вэ? /2 оноо/

A. Марксист онол B. Хүн ам зүйн онол

C. Бүтэц-чиг үүргийн онол D. Иргэншлийн онол E. Бэлгэ тэмдгийн харилцан үйлдлийн онол

5. Их Британи дахь аж үйлдвэржилтийн нөлөөгөөр XVIII зууны сүүлчээр үүссэн, орчин үед хамгийн түгээмэл тархсан нийгмийн хэв маяг аль нь вэ? /1 оноо/

A. Ан агнуурын нийгэм B. Цэцэрлэг аж ахуйн нийгэм C. Газар тариалангийн нийгэм

D. Аж үйлдвэржсэн нийгэм E. Аж үйлдвэржилтийн дараах нийгэм

Тодорхой зорилго

6. Т.Билтон нарын үзэж байгаагаар орчин үеийн буюу аж үйлдвэржсэн нийгмийн шинжид хамаарахгүй ойлголтыг олно уу? /2 оноо/

A. Гэр бүл, гэрлэлтийн харилцаа өөрчлөгдөж, гэрлэлтийн нас хойшилж ганц биеэр амьдрах зэрэг олон янзын төрөл хувилбарууд хүлээн зөвшөөрөгдөх болсон

B. Шинжлэх ухааны итгэл үнэмшлийн тогтолцоо тэргүүлэх үүрэгтэй

C. Орчин үеийн төрийн бүтэцтэй буюу үндэсний төрийн бүгд найрамдах засаглал бүхий төртэй

D. Нийгэм хамт олны зарчимд нийцүүлэх гэхээсээ хувийн хүсэл зоригийг хэрэгжүүлэхийг эрхэмлэдэг

E. Аж үйлдвэр нь эдийн засгийн гол талбар

7. Цэгийн оронд зөв хариултыг нөхөж бичнэ үү.

.....гэдэг нь нийгмийн гишүүд хувийн болон нийгмийн шинжээрээ зааглагдан хуваагдахыг хэлнэ. /1 оноо/

A. Тэгш бус байдал

B. Нийгмийн давхраа

C. Нийгмийн давхраажилт

D. Нийгмийн ялгарал

E. Нийгмийн нийтлэг

8. 1850 он хүртэлх Америкийн өмнөд, хэсэгт түгээмэл байсан гэж үздэг, орчин үед далд хэлбэрээр оршин байгаа давхраажилтын хэв маяг аль нь вэ? /1 оноо/

A. Анги бүлэг

B. Язгуур угсаа

C. Боолчлол

D. Нээлттэй нийгэм

E. Каст

9. Нийгмийн давхраажилтыг судлах шүүмжлэлт онолын гол хандлагыг тэмдэглэнэ үү. /2 оноо/

A. Бүх нийгэмд байр суурийн нэр хүндээс хамаарсан шатлал оршин байдаг.

B. Нэр хүнд, ажил мэргэжлийн байр суурийн ялгарал бол нийгмийн давхраажилтын суурь шалтгаан мөн

C. Өмч болон эрх мэдлийн ялгарал байх бөгөөд төр нь ноёрхогч ангийн эрх ашгийг хэрэгжүүлэхэд үйлчилж байдаг

D. Хөдөлмөрийн хуваарь нийгмийн зохион байгуулалтын үндэс болохын зэрэгцээ тэгш бус байдалд хүрэх үндсэн шалтгаан мөн

E. Нийгмийн давхраажилт бол уламжлал, тогтсон байдлаас шалтгаалан өөрөө жам ёсоор оршин тогтнодог үзэгдэл мөн

10. Бүтэц-чиг үүргийн онолын үүднээс Янки хотын нийгмийн давхраажилтыг судалсан судлаач

Л. Уорнерын жишээ загвар аль нь /2 оноо/

A. Ер бусын хүчинтэй харилцахыг онцгой чухал гэж үзэх нийгэмд шашны зүтгэлтэн, санваартан, бөө, шидтэний байр суурь илүү өндрөөр үнэлэгдэнэ.

B. Байгууллагад хувь хүмүүс материаллаг урамшуулал авах, эрх чөлөөтэй байх, нэр хүндтэй байх, чөлөөт цаг ихтэй байх зэрэг олон янзын ашиг сонирхолтой байна.

C. Дэлгүүрийн эзэн, эмчийг нэр хүндээр өөрөөсөө илүү гэж үзвэл түүнийг дэлгүүрийн эзэнээс дээд ангид оруулж судална.

D. Их хэмжээний баялагийг шинээр олж авсан баяныг бус, харин ядуурч хоосорсон язгууртныг хүмүүс илүүд хүндэтгэдэг

E. Ажил мэргэжлийн нэр хүндийн зэрэглэлийг тухайн хүний боловсрол, орлогын хэмжээгээр тодорхойлдог.

11. Юуг зөв гэж хүлээн зөвшөөрөх, бас юуг буруу, зохисгүй гэж үзэх талаар нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрхэм чанаруудыг илтгэдэг ойлголт аль нь вэ? /1 оноо/

12. "Өмнөх үеийн бүтээсэн нийгэм-соёлын уламжлалыг өвлүүлэх нь нийгмийн оршихуйн үндэс" хэмээх өгөгдөл нь соёлын аль чиг үүрэг болохыг олно уу? /1 оноо/
- A. Нэгтгэн, зохицуулах чиг үүрэг B. Үнэлэмж, хэм хэмжээний чиг үүрэг
C. Танин мэдэхүйн чиг үүрэг D. Бэлгэдлийн чиг үүрэг E. Үйл ажиллагааны чиг үүрэг
13. Олон улсын соёл, монголчуудын соёл, баруун монголын соёл гэх мэтээр ангилсан нь ямар шалгуур үзүүлэлтийг гол болгон ангилсан бэ? /2 оноо/
- A. Түүхэн хэв маягаар нь өөр байж болно
B. Соёл ямар нэг нийгмийн хэв маягт хамаарна
C. Хүмүүсийн сонголт хийх боломж өөр байж болно
D. Соёлын бүтээгч, хэрэглэгч нь өөр байж болно
E. Соёлын суурь үнэлэмжүүд өөр байж болно
14. Соёлын хэв маягуудыг түүхэн дарааллаар зөв байршуулсан нь аль вэ? /1 оноо/
1. Эртний 2. Хүй нэгдлийн 3. Дундад зууны
4. Сэргэн мандалтын 5. Шинэ үеийн 6. Орчин үеийн
- A. 1, 3, 2, 4, 6, 5 B. 1, 3, 2, 4, 5, 6 C. 1, 3, 2, 5, 4, 6
D. 2, 1, 3, 4, 5, 6 E. 2, 1, 4, 3, 5, 6
15. Соёлын төрөл бүрийн үйлчилгээ бий болгох, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагааг үндэсний соёлын бодлогод тусган хэрэгжүүлдэг. Монгол улс "Соёлын үйлдвэрлэл" үндэсний хөтөлбөрийг 2015 онд батлан хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү хөтөлбөрт хамаарахгүй өгөгдлийг олно уу. /2 оноо/
- A. Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх
B. Тухайн салбарт хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх
C. Улс, үндэснийхээ арвин баялаг өв уламжлал, ёс заншил, байгалийн өвөрмөц дүр төрх, соёлын нөлөөг сэргээх, хайрлан хамгаалах
D. Соёлын үйлдвэрлэлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, дэлхий нийтэд таниулан сурталчлах
E. Соёлын үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх
16. Ард түмэн өөрийн соёлын хэм хэмжээ, зан үйл, хэл, үнэлэмжийн баримжааллыг ухаарч ойлгох, тэрхүү соёлын байр сууринаас өөрийгөө ойлгох, тэрхүү соёлыг тээгч гэдгээ ухаарах байдлыг юу гэж үздэг вэ? /1 оноо/
- A. Соёлын адилсал B. Соёлын дархлаа C. Соёлын эрх чөлөө
D. Соёлын даяаршил E. Соёлын үйлдвэрлэл
17. "...Өнөөдөр удам дагасан малчид цөөрч байна. Малчин айлын хүүхдүүд их дээд сургуульд сурдаг. Сургуулиа төгсөөд буцаж мал малладаггүй. Өнөөдөр 5 хүүтэй айлын 5 хүүхэд бүгд төв газар амьдарч, тэдний малыг зарын дагуу очсон туслах малчин маллаж байна. Мал малчин хоёр байх боловч, мал дагасан соёл, удам дагасан малчин хоёр ховордох гээд байна..." Дээрх эх сурвалжид соёлын ямар ойлголтыг хөндөж байна вэ? /2 оноо/
- A. Соёлын цочирдолд орох B. Соёлын дархлаа алдагдах
C. Соёлын эрх чөлөө хязгаарлагдах D. Соёлын адилсал идэвхжих
E. Соёлын үйлдвэрлэл эрхлэх

18. Хэн ч байгалиас заяасан засаглах эрх, өөрөөр хэлбэл, хэнд ч бусдыгаа захирах төрөлх эрх гэж байхгүй. Эрх бол хүн бүрд хамаарах ёстой. Хүнд төрөлхөөс заяасан гурван эрх байна. Энэ нь амьдрах эрх, эрх чөлөөтэй байх эрх, өмчлөх эрх юм. Энэ нь аль сэтгэгчийн үзэл вэ? /1 оноо/
- A. Дж.Кэмпбелл B. Ж. Локк C. Э.Фромм
D. К.Оберг E. Э.Кассирер
19. Өргөн уудам нутагт тархан суух нүүдэлчид эргэх дөрвөн улиралд зөвхөн байгальтайгаа харилцаж, дураараа амьдардаг байсан нь тэдний аливаа дэг журамд орох дургүй, өөрийгөө хүндэтгэдэг, биеэ тоосон цагийн мэдрэмж муутай зан төрхийг бүрдүүлжээ. Байгалийн эрс тэс уур амьсгалд янз бүрийн нөхцөлтэй газраар байнга нутаг сэлгэн амьдардаг нь нүүдэлчдийг ямар ч шинэ нөхцөлд амархан дасан зохицдог зан байдалд сургажээ. Энэхүү эргэцүүлэл нь доорх өгөгдлийн алинд хамаарах вэ? /2 оноо/
- A. Соёлын эрх чөлөөний суурь зарчим B. Соёлын адилсал C. Соёлын даяаршил
D. Соёлын эрх чөлөө E. Соёлын эрх чөлөөг зөрчих хандлага
20. Тухайн жилийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн түвшний ерөнхий өсөлт буюу инфляцийн түвшинд харьцуулж тодорхойлдог ойлголтыг юу гэдэг вэ? /1 оноо/
- A. Бодит ДНБ B. Нэрлэсэн ДНБ C. Дотоодын нийт бүтээгдэхүүн
D. Үндэсний нийт бүтээгдэхүүн E. Нэг хүнд ногдох ДНБ
21. "Сүү ХК"-ны технологийн шинэчлэл хийсэн зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний хэрэглэгчийн ямар зардлаар тооцох вэ? /1 оноо/
- A. Эрх гэрийн хэрэглээний зардал B. Төрийн зардал C. Аж ахуйн нэгжийн зардал
D. Гадаадын хэрэглэгчийн зардал E. Цэвэр экспорт
22. Иргэн Б 2021 онд нэгэн компаний 1000 ширхэг нэгж хувьцааг, 1.000.000 төгрөгөөр хөрөнгийн биржээс худалдаж авсан. Жилийн дараа нэгж хувьцааны үнэ 1100 төгрөгт хүрсэн үед Б хувьцаагаа эргүүлэн худалдсан бол хэдэн төгрөгтэй болох вэ? /2 оноо/
- A. 1.110.000 B. 1.101000 C. 1.001.000
D. 1.111.000 E. 1.100.000
23. Зах зээлийн онолыг үндэслэгч, татвар хураалтын үндсэн зарчмуудыг тодорхойлсон сэтгэгч аль нь вэ? /1 оноо/
- A. Артур Лаффер B. Адам Смит C. Джон Мейнард Кейнс
D. Фридрих фон Хайек E. Хенри Бокли
24. Төрийн эдийн засаг бүдүүвчийн орхигдсон хэсэгт тохирох ойлголтыг сонгоно уу? /1 оноо/
- Төрийн эдийн засгийн бодлого
- Төрийн сангийн бодлого

↓

Хэрэгжүүлэгч нь:.....

↓

Улсын зардлыг нэмэгдүүлэх, татварын дарамтыг багасгах

↓

Нийт эрэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн уналт инфляцитай тэмцэх

Төрийн мөнгө зээлийн бодлого

↓

Хэрэгжүүлэгч нь: Төв банк

↓

Зээлийн хүүг бууруулах, гүйлгээн дэх мөнгийг өсгөх, бонд гаргах

↓

Нийт эрэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн уналт инфляцитай тэмцэх
- A. Санхүүгийн зохицуулах хороо B. Засгийн газар C. Улсын Их Хурал
D. Банкуудын холбоо E. Арилжааны банк

25. Татварын дарамтыг багасгах нь яагаад нийт эрэлтийг нэмэгдүүлдэг вэ? /2 оноо/

- A. ААН-ээс авах татварын хэмжээг бууруулснаар хэрэглэгчийн орлого, ААН-ийн орлого өснө. Ингэснээр хэрэглээний зардал болон хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж нийт эрэлт өснө.
- B. ААН -ээс авах татварын хэмжээг бууруулснаар хэрэглэгчийн орлого ААН-ийн орлого өснө. Ингэснээр хэрэглээний зардал, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж нийт эрэлт буурна.
- C. ААН -ээс авах татварын хэмжээг бууруулснаар хэрэглэгчийн орлого ААН-ийн орлого буурна.
- D. ААН -ээс авах татварын хэмжээг нэмэгдүүлснээр хэрэглэгчийн орлого ААН-ийн орлого буурна. Ингэснээр хэрэглээний зардал болон хөрөнгө оруулалтын хэмжээ буурч нийт эрэлт өснө.
- E. ААН-ийн татварын хувь хэмжээг бууруулах нь эргээд төрийн орлого буурах нэг шалтгаан болно.

26. Эдийн засгийн ухааны нэрт эрдэмтэн Фридрих фон Хайекийн намтар, үзэл баримтлалаас илүүц ойлголтыг олно уу. /2 оноо/

- A. Эдийн засгийн амьдрал, логик, ёс зүй болон социализмын шинжлэх ухааны үндэслэлийг бүх талаас нь судалж үзээд алдаатай байсан гэдгийг нотолсон.
 - B. Гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ болон үнийн түвшний хооронд шууд холбоо байхгүй гэдгийг баталсан.
 - C. Зах зээлийн эдийн засаг дахь төрийн идэвхтэй оролцоо нь түүнд зөвхөн хор учруулна.
 - D. Эх орны өмнө байгуулсан гавьяаг нь үнэлэн түүнд "Лорд" зэрэг олгосон.
 - E. Эдийн засгийн салбарт оруулсан хувь нэмрийг үнэлэн 1974 онд түүнд Нобелийн шагнал олгосон
27. Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэрийн газар байгуулах эсвэл худалдан авч болно. Үүнийг.....гэнэ. /1 оноо/


- A. Олон улсын худалдаа
 - B. Портфелийн хөрөнгө оруулалт
 - C. Хөдөлмөрийн шилжилт
 - D. Гадаад худалдааны бодлого
 - E. Гадаадын шууд хөрөнгө оруулалт
28. Эдийн засгийн хөгжил нь эдийн засгийн өсөлтийг бодвол илүү өргөн хүрээтэй ойлголт бөгөөд дараах үзүүлэлтүүдтэй холбогддог. Эдгээрээс хамааралгүй өгөгдлийг олно уу? /1 оноо/

- A. Хүний хөгжлийн үзүүлэлт сайжирсан
- B. Амьжиргааны түвшин дээшилсэн
- C. Аж үйлдвэржилт болон бүтцийн өөрчлөлт бий болсон
- D. Эдийн засгийн хараат байдал нэмэгдсэн
- E. Эдийн засаг өссөн

29. Ардчилсан нийгэмд хаан, ерөнхийлөгч, сайд хэн ч хуулиас дээгүүр эрх эдлэхгүй, зөвхөн хуулиар баталгаажсан эрхийг л эдэлнэ. Иргэн бүр хуулийг сахиж, түүнийг зөрчвөл хариуцлага хүлээдэг. Уг өгөгдөлд хамаарах ардчиллын үнэт зүйл аль нь вэ? /1 оноо/

- A. Тэгш эрх
- B. Хүний эрх, эрх чөлөө
- C. Хуулийн засаглал
- D. Иргэдийн улс төрийн оролцоо
- E. Эрх мэдлээ хэтрүүлэхэд хяналт тавих

30. Монгол улсын төрийн эрх мэдэл хуваарилалтын тогтолцоог харуулсан бүдүүвчийг ажиглаад тохирох хариултыг нөхнө үү. /1 оноо/



- A. Цагдаагийн ерөнхий газар
 - B. Улсын ерөнхий прокурор
 - C. Улсын их хурлын дарга
 - D. Тагнуулын ерөнхий газар
 - E. Ерөнхий сайд
31. "Төр, эдийн засаг, гэр бүлээс ангид орших нийгмийн хүрээг иргэний нийгэм гэнэ". Энэ нь иргэний нийгмийн тухай тодорхойлсон сэтгэгчдээс хэний үзэл санаа вэ? /1 оноо/

- A. К.Поппер
 - B. Г. Гегель
 - C. Р.Путнам
 - D. Аристотель
 - E. Р.Дарендорф
32. Иргэний нийгмийн төлөвшил нийгмийн хүрээнд ямар үйл ажиллагаагаар илрэн явагддаг вэ? /1 оноо/

- A. Хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, үүрэг хариуцлагыг адил тэгш эдлүүлэх
- B. Олон намын тогтолцоо бүхий ардчилсан сонгуулийн систем бүрэлдэх
- C. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн бие даасан байдлыг дэмжих
- D. Иргэд хувийн өмчтэй байж, өмчийн олон хэлбэрүүд эрх тэгш хөгжих
- E. Эрх мэдлийг зохистой тэнцвэржүүлэн хуваарилж хуулиар баталгаажуулах

33. Ардчилсан сонгуулийн саналаа нууцаар гаргах зарчмыг олно уу. /1 оноо/

- A. Нас хүйс, яс үндэс, мэргэжил, үзэл бодлоос үл шалтгаалан сонгуульд оролцох
- B. Сонгуулийн эцсийн үр дүн нь иргэдийн санал хураалтаар шийдэгдэх
- C. Сонгогч бүр ижил тооны санал гаргах, санал бүр адил жинтэй байх
- D. Чөлөөтэй сонголт хийн саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжтой байх
- E. Сонгогч зөвхөн өөрийн сонголтоор саналаа өгөх боломжтой байх


34. 2016 оны Улсын их хурлын сонгуульд МАН нийт сонгогчдын 45.69%-ийн санал авсан ч парламентын суудлын 85.5% буюу 65-ыг авсан байсан бол бусад нам эвслүүд нийт сонгогчдын 54.31%-ийн санал авсан хэдий ч парламентад 11 суудал авч байжээ. Энэхүү баримт нь сонгуулийн аль тогтолцооны онцлогийг харуулж байна вэ? /2 оноо/

- A. Мажоритари тогтолцооны энгийн олонх
- B. Пропорциональ тогтолцоо
- C. Мажоритари тогтолцооны үнэмлэхүй олонх
- D. Мажоритари тогтолцооны харьцангуй олонх
- E. Холимог тогтолцоо

35. Хувь хүний эрх, эрх чөлөөг хангах хуулийн засаглалыг бэхжүүлж, эдийн засаг дахь төрийн оролцоог хязгаарлах үнэт зүйлсийг эрхэм болгодог улс төрийн үзэл баримтлал аль нь вэ? /1 оноо/

- A. Неолиберализм
- B. Консерватизм
- C. Либерализм
- D. Социал демократ
- E. Неоконсерватизм

36. Улс төрийн намын үзэл баримтлалыг шугамд өгч тэмдэглэсэн байна. Тохирох үзэл баримтлалыг сонгож нөхнө үү? /1 оноо/



37. Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээлэл нь ард түмэнд үнэн зөв мэдээлэл хүргэхэд тодорхой зарчмуудыг мөрдлөг болгодог. Дараах өгөгдлүүдээс илүүц зүйл дурдсан бол олно уу. /1 оноо/

- A. Хэвлэл мэдээллийн ажилтнуудын эрх ашгийг хамгаалах
- B. Нэг хүний эрх ашгийн төлөө бус олон түмний тулд мэдээлэл дамжуулах
- C. Нас, хүйс, шашин шүтлэг үл харгалзан олон нийтэд хүргэх

D. Хэвлэл мэдээлэл нь зөвхөн төр засгийн дуу хоолой болох
 E. Боловсролын түвшин харгалзахгүйгээр бүх нийтэд тэгш хүргэх боломжийг хуулиар хангах
38. 2015 оны ардчилсан засаглал судалгааны дүнгээс: *Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь улс төрөөс хараат бус байдаг гэдэгтэй судалгаанд хамрагдсан иргэдийн 42,6 хувь нь санал нийлдэггүй, 23,0 хувь нь дунд зэрэг, 8,3 хувь нь санал нийлдэг* гэж үзжээ. Дээрх эх сурвалж ямар асуудлын тухай мэдээлэл вэ? /1 оноо/

- A. Мэдээллийн хэрэгслийн улс төрөөс хараат бус байдлын талаарх сэтгүүлчдээс авсан дүгнэлт
- B. Улс төрийн намуудын санхүүгээс хараат бус байдлын талаарх иргэдийн санал
- C. Сонирхлын бүлгүүд улс төрөөс хараат бус байдлын талаарх иргэдийн санал
- D. Иргэний нийгмийн зохион байгуулалтын үйл ажиллагааны шаардлага
- E. Мэдээллийн хэрэгслийн улс төрөөс хараат бус байдлын талаарх иргэдийн төсөөлөл

39. “Хүн төрөлхтний гэр бүлийн бүх гишүүдийн хүний эрхэм чанар болон салшгүй эрхүүдийг хүлээн зөвшөөрөх нь дэлхий дээрх энх тайван, эрх чөлөө шударга ёсны үндэс” гэж ямар баримт бичигт тусгасан байдаг вэ? /2 оноо/

- A. НҮБ-ын “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”
- B. “Иргэний ба улс төрийн эрхийн ОУ-ын пакт”
- C. “Сирусын бортого”
- D. Монгол улсын Үндсэн хууль
- E. “Эрх чөлөөний харти”

40. Хүний эрхийн үндсэн зарчмуудыг ойлголттой нь зөв тохируулна уу? /1 оноо/

a	Тэгш байдлыг хангах	1	Иргэний, улс төрийн, нийгэм эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг хүний бүх эрхүүд нэгдмэл байдаг
b	Хуваагдашгүй байх	2	Төр нь хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахаас татгалзах, эсхүл хэсэг хүмүүсийн эрхийг хүндэтгэж, хамгаалж, хангаад бусад хүмүүсийн эрхээс татгалзах ёсгүй
c	Хариуцлага тооцох	3	Хүн болж төрснийхөө хувьд хүн бүр ижил үнэ цэнтэй байж адил хүндэтгэлийг эдэлнэ

- A. a1, b3, c2
- B. a1, b2, c3
- C. a3, b2, c1
- D. a3, b1, c2
- E. a2, b3, c1

41. Иргэд өндөр наслах, эмнэлгээр эмчлүүлэх, өвдөх, тахир дутуу болох, ажилгүй болох зэрэг тохиолдолд нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн туслалцааг авах, түүнийг дуусгавар болгохтой холбогдон үүсч буй харилцааг нэрлэнэ үү. /2 оноо/

- A. Иргэний эрх зүйн харилцаа
- B. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа
- C. Нийгмийн хамгааллын эрх зүйн харилцаа
- D. Захиргааны эрх зүйн харилцаа
- E. Үндсэн хуулийн эрх зүйн харилцаа

42. Даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо өмнө төлсөн нөхцөлд тэтгэмж авах эрх үүснэ. Ажилгүйдлийн тэтгэмж олгох нөхцөлийг олно уу? /2 оноо/

- A. Ажилгүй болохоосоо өмнө 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
- B. Ажилгүй болохоосоо өмнө 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
- C. Ажилгүй болохоосоо өмнө 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 12 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд

D. Ажилгүй болохоосоо өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд

E. Ажилгүй болохоосоо өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд

43. Эрх зүйд захирагдах ёсны дагуу орчин цагийн үндсэн хуульд удирдлага болгодог зарчмуудаас хамааралгүй ойлголтыг олно уу. /2 оноо/

- A. Төрийн байгууламжийг тодорхой тусгасан байх
- B. Ардчилсан дэглэм, бүгд найрамдах засаглалыг хүлээн зөвшөөрөх
- C. Хүнлэг энэрэнгүй байдлыг бий болгох
- D. Засаг, төрийн эрх мэдлийг төвлөрүүлэх
- E. Үндсэн хуулийг хянах тогтолцоог бүрдүүлэх.

44. Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргахдаа бүрдүүлэх шаардлагатай нэхэмжлэлийн бүрдүүлбэрүүдээс хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/

- A. Улсын тэмдэгтийн хураамж буюу шүүхээс үйлчилгээ үзүүлсний хөлсийг хуульд заасан хэмжээгээр төлсөн баримт
- B. Нэхэмжлэгчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, утасны дугаар, хуулийн этгээд бол оршин байгаа газар
- C. Эрх зөрчигчийн буюу хэргийн хариуцагчийн овог, эцгийн нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг
- D. Нэхэмжлэлийн үнэ буюу хэдэн төгрөг нэхэмжилж байгаа талаар бичих
- E. Нэхэмжлэгчийн нийгмийн гарал, боловсролын түвшин

45. Хүний эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн баталгааг бий болгох /үйлчилгээний хүртээмжийг амар хялбар болгох, эмзэг бүлгийг эн тэргүүнд анхаарч, тэгш байдлыг бүрдүүлэх/ арга хэмжээ авах нь төрийн ямар үүрэгт орох вэ? /2 оноо/

- A. Хамгаалах үүрэг
- B. Хүндэтгэх үүрэг
- C. Хангах үүрэг
- D. Ахиц дэвшил гаргах үүрэг
- E. Нөлөөлөх үүрэг

46. Захиргааны байгууллагын хууль бус актын улмаас эрх зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд нь дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах хугацааг хэд хоногийн дотор байхаар тогтоож өгсөн вэ? /1 оноо/

- A. 60 хоног
- B. 14 хоног
- C. 45 хоног
- D. 30 хоног
- E. 7 хоног

47. Баянгол дүүргийн Засаг дарга 2017 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 59 дүгээр захирамжаар иргэн Б-д, мөн оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 274 дүгээр захирамжаар иргэн Г-д газар олгохдоо иргэн Б-ийн нэр дээр байдаг “Очир” дэлгүүрийн газартай давхцал бүхий хэсгийг давхардуулан олгосон байна. Дээрх тохиолдолд иргэн Б эрх зөрчигдсөн гэж үзэн дээд шатны байгууллагад гомдол гаргажээ. Б-гийн хувьд аль субъектэд хамаарах вэ? /2 оноо/

- A. Хуулийн этгээд
- B. Хариуцагч
- C. Гомдол гаргаж буй иргэн
- D. Албан тушаалтан
- E. Гуравдагч этгээд

48. Судлаачид Монгол улсыг олон улсын харилцааны улс оролцогчын хувьд “бага улс” гэсэн статуст хамааруулдаг. Тэгвэл уг статуст хамаарахгүй өгөгдлийг олно уу. /1 оноо/

- A. Дэд бүтэц хөгжөөгүй, хүн ам цөөн
- B. Улс төрийн тогтвортой байдал бүрэн хангагдсан

- С. Далайд гарцгүй, эх газрын байршилтай бүтээгдэхүүн нь хоёр хөршөөс хамааралтай
- Е. Орос, Хятад гэсэн хоёр их гүрний дунд оршдог
49. Олон улсын улс төр, эрх зүй, эдийн засаг, соёлын олон талт харилцаанд гадаад бодлогоороо дамжуулан оролцох үйл ажиллагааны цар хүрээ, нөлөөллөөр тодорхойлогдох ойлголтыг олно уу? /2 оноо/
- A. ОУХ-нд оролцох зарчим
B. ОУХ-нд оролцох үйл ажиллагааны чиглэл
C. ОУХ-нд оролцох нөлөө
D. ОУХ-нд оролцох үүрэг
E. ОУХ-ны тэргүүлэх чиглэл
50. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал баримт бичгийн /6 дугаар зүйлээс/ гадаадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах бодлогоос үл тохирох өгөгдлийг олно уу? /2 оноо/

- A. Монгол улсаас гадаад улсад суугаа өөрийн иргэдийнхээ бүртгэл, судалгааг хөтөлж, тэдэнд шаардлагатай үед туслалцаа, дэмжлэг үзүүлэх
- B. Монгол улсаас гадаад улсад суугаа өөрийн иргэн хуулийн этгээдийн эрх ашгийг үндэсний болон тухайн улсын хууль олон улсын гэрээний хүрээнд хамгаалах
- C. Гадаадад байгаа иргэддээ хууль ёсны эрх, үүрэг хариуцлагын талаарх шаардлагатай мэдээлэл зөвлөгөө өгөх
- D. Гадаадад зорчиж байгаа иргэдийг хар тамхи, хүний наймаа зэрэг гэмт хэргээс сэргэмжлүүлэх, хэрэгт холбогдож хохирогсдын эрхийг хамгаалах
- E. Гадаад улсад суугаа өөрийн иргэдийн бизнесийн үйл ажиллагаанд хамтран ажиллахдаа тодорхой шалгуур тавих

51. Эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхийг бүрдүүлж, тодорхой салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай бүс нутгийн болон олон улсын интеграцид нэгдэх, судалгаа, тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлэх ойлголтыг юу гэж үзэх вэ? /2 оноо/
- A. Эдийн засгийн олон тулгуурт бүтэц
B. Эдийн засгийн аюулгүй байдал
C. Гадаад худалдаа, хөрөнгө оруулалт
D. Олон улсын тээвэр, дэд бүтэц
E. Эдийн засгийн бие даасан байдал

52. Тодорхой чиглэл, хүрээнд зорилго тавьж хэрэгжүүлдэг, иргэн байгууллагад түлхүү нээлттэй, сайн дурын шинжтэй, иргэний нийгмийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын харилцааны улс бус оролцогч аль нь вэ? /1 оноо/
- A. Олон улсын хэвлэл мэдээллийн сүлжээ
B. Олон улсын байгууллага
C. Үндэстэн дамнасан корпорацууд
D. Олон улсын төрийн бус байгууллага
E. Олон улсын гэмт хэргийн сүлжээ

53. Дараах ойлголтуудыг харгалзах утгатай нь зөв тохируулна уу. /1 оноо/

a	Нөлөө бүхий хувь хүн	1	Транспаренси Интернэшл
b	Олон улсын төрийн бус байгууллага	2	Элон Маск, Жорж Сорос
c	Олон улсын хэвлэл мэдээллийн сүлжээ	3	BBC, CNN

- A. a2, b3, c1
B. a3, b2, c1
C. a2, b1, c3
D. a3, b1, c2
E. a1, b3, c2

54. 2006 онд Монгол улсын Засгийн газрын зүгээс манлайлан санаачилга гаргаж үүсгэн байгуулалцсан олон улсын байгууллага аль нь вэ? /1 оноо/

- A. ЮНЕСКО-гийн гүйцэтгэх зөвлөл
B. Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын олон улсын судалгааны төв
C. Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг /АОХН/
D. Олон улсын худалдааны эрх зүйн комисс
E. Олон улсын атомын энергийн агентлаг

55. Монгол улс Япон улстай 1972 онд дипломат харилцаа тогтоосон түүхтэй. Монгол улс ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд 1990-ээд оноос хоёр улсын харилцаа эрчимтэй хөгжиж түншлэлийн харилцаа ямар түвшинд хүрсэн бэ? /2 оноо/
- A. Олон талт хамтын ажиллагааны түншлэл
B. Иж бүрэн стратегийн түншлэл
C. Иж бүрэн түншлэл
D. Өргөн хүрээтэй түншлэл
E. Стратегийн түншлэл

56. Хатуу хүчний бодлого нь зөөлөн хүчний бодлогоос зарчмын ялгаа, үйлдлийн төрөл, өндөр хамааралтай хүчний үндэс зэргээрээ ялгаатай байдаг. Тэгвэл хатуу хүчний бодлогын зарчим аль вэ? /1 оноо/

- A. Эдийн засгийн хүч, урамшуулал
B. Албадлага
C. Удирдамж
D. Цэргийн хүч, эдийн засгийн хориг
E. Захирах чадвар

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай нийт 20 оноотой.

Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.

- 2.1 Хүний эрхийг хамгаалах үндэсний болон олон улсын байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлүүдийг зөв харгалзуулна уу. /5 оноо/

a	НҮБ	1	Ерөнхий Ассамблей, Аюулгүйн зөвлөл, Эдийн засаг, нийгмийн зөвлөл, Хүний эрхийн комисс, Эмэгтэйчүүдийн байдлын тухай НҮБ-ын комисс
b	Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо	2	Олон улсын шүүх, Хүний эрхийн хороо, Хүүхдийн эрхийн хороо, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтыг устгах хороо
c	Хүний эрхийн зөрчил	3	Хүний эрхийг хангах, хамгаалах олон улсын тогтолцоог бүрдүүлэн ажиллах чиг үүргийг гүйцэтгэдэг
d	НҮБ-ын дүрэмд үндэслэгдсэн байгууллагууд	4	Үндэсний хууль тогтоомж, олон улсын болон бүс нутгийн гэрээ, конвенцоор болон бүс нутгийн гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрхийг төр өөрийнхөө ямар нэгэн үйлдлээр зөрчсөн, эсхүл төрөөс хэрэгжүүлэх эдийн засаг, нийгэм, хууль зүйн үүрэг биелэгдээгүй байхыг хэлнэ.
e	Гэрээнд үндэслэгдсэн байгууллагууд	5	Монгол улсын Үндсэн хуульд зааснаар төр нь хүний эрхийн талаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийн тулд тодорхой байгууллага, тогтолцоог бүрдүүлэн ажилладаг.

- 2.2 Инфляцид холбогдох ойлголтуудыг зөв харгалзуулна уу. /5 оноо/

a	Инфляци	1	Үйлдвэрлэлийн чухал нөөцүүдийн үнэ, эсвэл цалин өсөх үед бүтээгдэхүүний үнэ дагаж өсөх үзэгдэл
b	Эрэлтээс үүдэлтэй инфляци	2	Бараа, бүтээгдэхүүний үнэ огцом, түргэн бөгөөд жигд бусаар өсөх үзэгдэл. Тухайлбал инфляци 54.2 %-д хүрсэн
c	Зардлаас үүдэлтэй инфляци	3	Нийт эрэлтийн хэмжээ нь нийт нийлүүлэлтийн хэмжээнээс давж үнэ өсөх үзэгдэл
d	Мөлхөө инфляци	4	Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өсөж хүн амын худалдан авах чадвар буурах үзэгдэл
e	Цогио инфляци	5	Бараа, бүтээгдэхүүний үнэ аажмаар хэлбэрэлтгүй өсөх үзэгдэл. Тухайлбал инфляци 4.7%-д хүрсэн

2.3 Дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу. /5оноо/

a	Хатуу хүч	1	Бусдад нөлөөлөх байдлаар өөрийн орны гадаад харилцааны бодлогыг сурталчилах, өөрийн орны талаар эерэг сэтгэгдэл бий болгох үйл ажиллагаа
b	Соёлын дипломат ажиллагаа	2	Ямар ч үед аль ч нөхцөлд ядарч зүдэрсэн эмзэг бүлгийн хүмүүсийн эрх ашгийг дээдэлж, тэдний ашиг сонирхлыг хүндэтгэсэн үйл ажиллагаа явуулахыг шийдвэр гаргагчид болон манлайлагчдад уриалах, ятган үнэмшүүлэх явдал
c	Эдийн засгийн дипломат ажиллагаа	3	Хоёр болон олон талт үйл ажиллагаанд тулгуурлан улс орныхоо худалдаа санхүүгийн ашиг сонирхлыг дипломат аргаар хангах явдал
d	Хүмүүнлэгийн дипломат ажиллагаа	4	Их гүрнүүд цэрэг, эдийн засгийн хүч чадавхдаа тулгуурлан хүчээр түрий барих бодлого хэрэгжүүлэх
e	Цахим дипломат ажиллагаа	5	Улсуудын харилцааг бэхжүүлэх, хамтын ажиллагааг бататгах буюу үндэсний эрх ашгаа хөхиүлэн дэмжих зорилгоор үзэл санаа, үнэт зүйл, уламжлал зэрэг бусад талуудын солилцоон дээр үндэслэдэг

2.4 Соёлын аялал жуулчлалын зарчим, төрлүүдийг ойлголтуудтай зөв харгалзуулна уу.

/5оноо/

a	Дотоодын аялал жуулчлал	1	2022 оны 2 дугаар улирлаас гадаад руу чиглэсэн Монгол улсын иргэд, Монгол руу чиглэсэн гадаад жуулчдын хөдөлгөөн эрс нэмэгдэж аялал жуулчлалын салбарт сэргэлт ажиглагдаж байна.
b	Олон улсын аялал жуулчлал	2	Эдийн засгийн өсөлт, нийгмийн тэгш байдлыг хангаж, бие хүний хөгжлийг дэмжин, ажлын байрыг бий болгох
c	Орон нутгийн хүн амын амьжиргаа, нийгэм эдийн засгийн хөгжилд үр ашгаа өгөх	3	Өмнөговь аймгийн удирдлага, иргэд, аж ахуйн нэгжүүд Ёлын ам, Молцог элс, Хэрмэн цав, зэрэг газруудыг хайрлан хамгаалж соёл, түүх, археологи, байгалийн аялалыг хөгжүүлэхээр зорьж байна
d	Байгалийн болон соёлын өвийн	4	Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас иргэд гадагш гэхээсээ илүү орон нутаг дахь байгаль, түүх соёлын дурсгалт газруудаар аялах байдал нэмэгдсэн

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025

ГАРААНЫ ҮНЭЛГЭЭ НИЙГМИЙН УХААН Хувилбар D

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавартай нийт 80 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй.

Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай. Амжилт хүсье.

1. Хамтран тоглох явцдаа дүрмээ хэлэлцэн тогтож, зохион байгуулалтад орж, бие даасан шийдвэр гаргах, гэр бүлээс гадуурх үйл ажиллагаанд оролцоход суралцдаг нийгэмшилтийн агент аль нь вэ? /1 оноо/

- A. Үе тэнгийнхэн B. Сургууль C. Гэр бүл
D. Хэвлэл мэдээлэл E. Ажлын байр

2. Нийгэмшилтийн талаарх ойлголтуудыг тохирох утгаар нь зөв харгалзуулна уу? /2 оноо/

a	Хүүхэд нас	1	Шинэ байр суурь, үүргийн шаардлага, хүлээлтийг хүлээн авах, арга барил эзэмших, туршлага хуримтлуулах
b	Насанд хүрэгчид	2	Хөгжих гэхээсээ бие, сэтгэхүйн чадамж буурсантайгаа зохицох, даван туулах
c	Ахмад настан	3	Итгэж байсан зүйлээсээ ухарч, хатуу ширүүн дэг журамд зохицон өөрийгөө хүлээн авах, дүр зургаа өөрчлөх гарцаагүй нөхцөлд орох
d	Дахин нийгэмшилт	4	Ойр дотныхонтойгоо харилцах, дуурайх, дүрд тоглох багаар тоглох зэргээр хөгждөг

- A. a2, b1, c3, d4 B. a4, b1, c3, d2 C. a4, b1, c2, d3
D. a3, b4, c1, d2 E. a2, b3, c4, d1

3. Гажуудал нь нийгмийн бүтэц ба соёлоосоо хамаараад харилцан адилгүй байдаг. Жишээ нь, Шинэ Гвинейн Чамбули омгийнхны эрчүүд гэртээ сууж, нүүрээ будаж, эмэгтэйдээ тоогдохыг хичээхийг хэвийн гэж тооцдог бол манайд ийм эрэгтэйчүүдэд нэр хоч өгч, ад үзэн буруушаадаг. Энэхүү жишээ ямар ойлголтыг илэрхийлж байна вэ? /2 оноо/

- A. Гажуудлын сөрөг үр дагавар B. Гажуудлын харьцангуй мөн чанар
C. Гажуудлын эерэг үр дагавар D. Албан ёсны хяналт E. Соёлын зохицуулгын хомсдол

4. Нийгмийг амьд биетэй төстэй хэмээн үзэж, эд эрхтэн нь тухайн амьд биеийг амьдруулахын төлөө үүрэг гүйцэтгэж байдгийн адил нийгмийн институт нь нийгмийн болон бусад институтийн оршин тогтнолын төлөө тодорхой үүрэг гүйцэтгэж байдаг гэж үздэг онол аль вэ? /2 оноо/

- A. Марксист онол B. Иргэншлийн онол
C. Бэлгэ тэмдгийн харилцан үйлдлийн онол D. Бүтэц-чиг үүргийн онол E. Хүн ам зүйн онол

5. Энгийн багаж ашиглан тариалангийн аж ахуй эрхэлдэг ч, нэмүү өртөг бүтээх түвшинд хүрээгүй, олон төрлийн овгуудаас тогтсон нийгэм нь нийгмийн аль хэв маягт хамаарагдах вэ? /1 оноо/

- A. Ан агнуурын нийгэм B. Аж үйлдвэржилтийн дараах нийгэм
C. Газар тариалангийн нийгэм
D. Аж үйлдвэржсэн нийгэм E. Цэцэрлэг аж ахуйн нийгэм

6. Т.Билтон нарын үзэж байгаагаар уламжлалт буюу аж үйлдвэржилтээс өмнөх нийгмийн шинжид хамаарахгүй ойлголтыг олно уу? /2 оноо/

- A. Газар тариалангийн аж ахуй болон түүнээс өмнөх хэлбэрийн аж ахуйтай
B. Шашны эсвэл домгийн итгэл үнэмшлийн тогтолцоотой
C. Уламжлалт төрийн бүтэцтэй, угсаа залгамжлах ёс бүхий хаант засаглал эсвэл төрийн бүтэцгүй нийгэм

D. Хүний амьдралын үйл ажиллагааны гол талбар нь өрх, гэр бүлийн хүрээ байна

E. Нийгэм-хамт олны зарчимд нийцүүлэх гэхээсээ хувийн хүсэл зоригийг хэрэгжүүлэхийг эрхэмлэдэг

7. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу.гэдэг нь эдийн засгийн баялаг, нэр хүнд, эрх мэдэлд хүрэх адил бус боломж бүхий байдлыг хэлнэ. /1 оноо/

- A. Нийгмийн нийтлэг B. Нийгмийн давхраа C. Нийгмийн давхраажилт
D. Тэгш бус байдал E. Нийгмийн ялгарал

8. Давхраа харгалзалгүйгээр гэрлэх нь харьцангуй нээлттэй, мөн онцгой гавьяа байгуулах эсвэл хэргэм зэргийг худалдаж авах замаар байр сууриа өөрчлөх боломжтойгоороо онцлог давхраажилтын хэв маяг аль нь вэ? /1 оноо/

- A. Каст B. Анги бүлгийн C. Язгуур угсаа
D. Боолчлол E. Нээлттэй нийгэм

9. Нийгмийн давхраажилтыг судлах зөрчилдөөний онолын гол хандлагыг тэмдэглэнэ үү. /2 оноо/

- A. Нэр хүнд, ажил мэргэжлийн байр суурийн ялгарал бол нийгмийн давхраажилтын суурь шалтгаан мөн.
B. Хөдөлмөрийн хуваарь нийгмийн зохион байгуулалтын үндэс болохын зэрэгцээ тэгш бус байдалд хүрэх үндсэн шалтгаан мөн.
C. Бүх нийгэмд байр суурийн нэр хүндээс хамаарсан шатлал оршин байдаг.
D. Эрх мэдэл бүхий хэсэг өөрийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх давуу нөхцөлд байх бол бусад нь тэрхүү ашиг сонирхлыг хэрэгжүүлэхээр нөхцөлд байна
E. Нийгмийн давхраажилт бол уламжлал, тогтсон байдлаас шалтгаалан өөрөө жам ёсоор оршин тогтнодог үзэгдэл мөн.

10. Бүтэц-чиг үүргийн онолын үүднээс нийгмийн давхраажилтыг судалсан судлаач

T. Парсонсын үзэл санаа аль нь вэ? /2 оноо/

- A. Дэлгүүрийн эзэн, эмчийг нэр хүндээр өөрөөсөө илүү гэж үзвэл түүнийг дэлгүүрийн эзэнээс дээд ангид оруулж судална.
B. Байгууллагад хувь хүмүүс материаллаг урамшуулал авах, эрх чөлөөтэй байх, нэр хүндтэй байх зэрэг олон янзын ашиг сонирхолтой байна.
C. Ер бусын хүчинтэй харилцахыг онцгой чухал гэж үзэх нийгэмд шашны зүтгэлтэн, санваартан, бөө, шидтэний байр суурь илүү өндөрөөр үнэлэгдэнэ.
D. Их хэмжээний баялгийг шинээр олж авсан баяныг бус, харин ядуурч хоосорсон язгууртныг хүмүүс илүүтэй хүндэтгэдэг.
E. Ажил мэргэжлийн нэр хүндийн зэрэглэлийг тухайн хүний боловсрол, орлогын хэмжээгээр тодорхойлдог.

11. Хүмүүсийн зан төлөвийг зохицуулдаг дэг журам, хууль дүрэм, ёс заншил зэргийг бүхэлд нь илтгэдэг ойлголт аль нь вэ? /1 оноо/

- A. Бэлгэ тэмдэг B. Хэл C. Үнэлэмж
D. Хэм хэмжээ E. Мэдлэг

12. Соёлын үзэгдлүүд тэмдгэн хэлбэрээр оршдог. Тэмдгийн хамгийн түгээмэл хэлбэр нь хэл. Энэ нь соёлын аль чиг үүрэг болохыг олно уу? /1 оноо/

- A. Танин мэдэхүйн чиг үүрэг B. Үнэлэмж, хэм хэмжээний чиг үүрэг
C. Бэлгэдлийн чиг үүрэг
D. Үйл ажиллагааны чиг үүрэг E. Нэгтгэн, зохицуулах чиг үүрэг

13. Ёс суртахууны соёл, шашны соёл, дугуй сонирхогчдын соёл гэх мэтээр ангилсан нь ямар шалгуур үзүүлэлтийг гол болгон ангилсан бэ? /2 оноо/

- A. Соёл нь ямар нэг нийгмийн хэв маягт хамаарна
- B. Соёлын суурь үнэлэмжүүд өөр байж болно
- C. Хүмүүсийн сонголт хийх боломж өөр байж болно
- D. Соёлын бүтээгч, хэрэглэгч нь өөр байж болно
- E. Түүхэн хэв маягаар нь өөр байж болно

14. Соёлын түүхэн хэв маягуудаас аж ахуй эрхлэлтийг шалгуур болгосон ангилалд багтах төлөөллийг олно уу. /1 оноо/

- | | | |
|----------------------------|------------------------|---------------------|
| 1. Ан агнуур | 2. Түүвэрлэгчдийн соёл | 3. Нүүдэлчдийн соёл |
| 4. Газар тариаланчдын соёл | 5. Өрнийн | 6. Дорнын |
| A. 1, 3, 4, 6 | B. 1, 2, 3, 4 | C. 1, 2, 4, 6 |
| D. 1, 3, 4, 5 | E. 1, 2, 3, 6 | |

15. "Соёлын үйлдвэрлэл" үндэсний хөтөлбөрийг соёлын үйлдвэрлэл үйлчилгээ явуулах боломж, нийгэм, эдийн засгийн үр ашгийг харгалзан үзэж дараах хүрээнд хэрэгжүүлэхээр заасан байдаг. Энэ хүрээнд хамаарахгүй өгөгдлийг олно уу. /2оноо/

- A. Соёлын өв, уламжлал, зан заншил, соёлын аялал жуулчлал
- B. Дизайн, дүрслэх урлаг, хувцас загвар, гар урлал, уран зураг
- C. Тайзны уран бүтээл урлагийн бүх төрлийн тоглолт үзүүлбэр
- D. Кино урлагийн бүх төрөл
- E. Нүүдлийн сонгодог бэлчээрийн аж ахуйг эрчимжүүлсэн хэлбэрт шилжүүлэх

16. 1970-аад оны II хагасаас энэхүү ойлголт нийгэм, хүмүүнлэгийн ухаанд хэрэглэгдэж эхэлжээ. Энэхүү ойлголтыг манай судлаачид "соёлын ижилсэл", "соёлын өөрийншил", "соёлын өвөр төрх" гэх зэргээр нэрлэдэг бол энэ нь аль ойлголт вэ? /1оноо/

- A. Соёлын дархлаа
- B. Соёлын даяаршил
- C. Соёлын эрх чөлөө
- D. Соёлын цочирдол
- E. Соёлын адилсал

17. "...Манай малчид уламжлалт эд өлгийн зүйлс хэрэглэхээ больж байна. Жишээ нь айргаа хөхүүрэндээ эсгэхээ больж хятадын цэнхэр саванд эсгэдэг боллоо. Гэрийн бүслүүрээ малынхаа үс хялгасаар биш, хятадын дээсээр хийдэг боллоо, морио унахаа больж мотоцикл хэрэглэдэг боллоо..." Энэхүү эх сурвалжид соёлын ямар ойлголтыг хөндөж байна вэ? /2 оноо/

- A. Соёлын дархлаа алдагдах
- B. Соёлын адилсал идэвхжих
- C. Соёлын эрх чөлөө хязгаарлагдах
- D. Соёлын цочирдолд орох
- E. Соёлын үйлдвэрлэл эрхлэх

18. Хүн бүрийн өвөрмөц боломжийг хүлээн зөвшөөрч, тэр бүрийг хөгжүүлэхээр тэмцэнэ гэдэг хүмүүний соёлын хөгжлийн үнэт ололт яах аргагүй мөн. Гэтэл одоо энэ ололтод аюул занал нөмрөөд байна. Хуурмаг эрх чөлөө нь хүнийг ганцаардуулж, хорвоо ертөнцөд итгэх юмгүй, айж хургасан нэгэн болгодог. Энэ нь аль сэтгэгчийн үзэл вэ? /1 оноо/

- A. Э.Фромм
- B. Дж.Кэмпбелл
- C. Ж. Локк
- D. К.Оберг
- E. Э.Кассирер

19. Өргөн уудам нутагт тархан суух нүүдэлчид эргэх дөрвөн улиралд зөвхөн байгальтайгаа харилцаж, дураараа амьдардаг байсан нь тэдний аливаа дэг журамд орох дургүй, өөрийгөө хүндэтгэдэг, биеэ тоосон цагийн мэдрэмж муутай зан төрхийг бүрдүүлжээ. Байгалийн эрс тэс уур амьсгалд янз бүрийн нөхцөлтэй газраар байнга сэлгэн амьдардаг нь нүүдэлчдийг ямар ч шинэ нөхцөлд амархан дасан зохицдог зан байдалд сургажээ. Энэхүү эргэцүүлэл нь доорх өгөгдлүүдийн алинд хамаарах вэ? /2 оноо/

- A. Соёлын эрх чөлөөний суурь зарчим
- B. Соёлын даяаршил
- C. Соёлын эрх чөлөө
- D. Соёлын үйлдвэрлэл
- E. Соёлын эрх чөлөөг зөрчих хандлага

20. Улс орнуудын эдийн засгийн өсөлт болон иргэдийн амьжиргааны түвшинг харьцуулан хэмжих зорилгоор өргөнөөр хэрэглэдэг эдийн засгийн үзүүлэлт аль нь вэ? /1 оноо/

- A. Үндэсний нийт бүтээгдэхүүн
- B. Нэрлэсэн ДНБ
- C. Бодит ДНБ
- D. Нэг хүнд ногдох ДНБ
- E. Дотоодын нийт бүтээгдэхүүн

21. Улаанбаатар Налайх чиглэлийн 15 км авто замыг нийслэлийн төсвөөс санхүүжүүлж ашиглалтад оруулсан бол дотоодын нийт бүтээгдэхүүний хэрэглэгчийн ямар зардлаар тооцох вэ? /1 оноо/

- A. Цэвэр экспорт
- B. Аж ахуйн нэгжийн зардал
- C. Өрх гэрийн хэрэглээний зардал
- D. Гадаадын хэрэглэгчийн зардал
- E. Төрийн зардал


22. Иргэн А 2021 онд нэгэн компаний жилийн хугацаатай, 10%-ийн хүүтэй бондыг 1000.000 төгрөгөөр авсан. А жилийн дараа хэдэн төгрөгтэй болох вэ? /2 оноо/

- A. 1.100.000
- B. 1.110.000
- C. 1.001.000
- D. 1.101000
- E. 1.111.000

23. Татварын орлого болох хураасан татварын нийт хэмжээ, татварын хувь хэмжээнээс хамаардаг зүй тогтолыг тайлбарлаж графикаар илэрхийлсэн эдийн засагч хэн бэ? /1 оноо/

- A. Джон Мейнард Кейнс
- B. Фридрих фон Хайек
- C. Артур Лаффер
- D. Адам Смит
- E. Хенри Бокли

24. "Төрийн эдийн засгийн бодлого" бүдүүвчийн орхигдсон хэсэгт тохирох ойлголтыг сонгоно уу? /1 оноо/



- A. Засгийн газар
- B. Төв банк
- C. Санхүүгийн зохицуулах хороо
- D. Банкуудын холбоо
- E. Арилжааны банк

25. Улсын зардлыг нэмэгдүүлэх нь нийт эрэлтийг яагаад нэмэгдүүлдэг вэ? /2 оноо/

- A. Төрөөс "Засгийн газрын хөтөлбөр, төсөл" боловсруулж түүнийг хэрэгжүүлэхэд зориулж зардлаа багасгаж болно. Ингэснээр нийт эрэлтийг нэмэгдүүлнэ.
- B. Төр өөрийн хөрөнгөөр нийтийн шинжтэй ажил зохион байгуулж болно. Ингэснээр ажилгүй олон хүмүүс ажилтай болж тэдний орлого нэмэгдсэнээр эрэлтийг бууруулна.
- C. Төрөөс "Засгийн газрын хөтөлбөр, төсөл" боловсруулж түүнийг хэрэгжүүлэхэд зориулж зардлаа ихэсгэж болно. Ингэснээр нийт эрэлт буурна.
- D. Төр өөрийн хөрөнгөөр нийтийн шинжтэй ажил зохион байгуулж болно. Ингэснээр ажилгүй олон хүмүүс ажилтай болж тэдний орлого нэмэгдсэнээр эрэлтийг нэмэгдүүлнэ
- E. Төсвийн зардлыг бууруулж нийтийн шинжтэй ажил зохион байгуулахгүй байх нь нийт эрэлтийг нэмэгдүүлдэг.

26. Эдийн засгийн ухааны нэрт эрдэмтэн Джон Мейнард Кейнсийн намтар, үзэл баримтлалаас илүүц ойлголтыг олно уу. /2 оноо/

- A. Тэрээр сонгодог уран зохиол, хөгжим, спортоор хичээллэхийн зэрэгцээ хөрөнгийн бирж дээр тоглож асар их амжилт олсон
 B. Эх орны өмнө байгуулсан гавьяаг нь үнэлэн түүнд "Лорд" зэрэг олгосон
 C. Зах зээлийн тогтолцоо нь эдийн засгийн уналтаас өөрийгөө аварч чадахгүй гэдгийг баталж төрийн оролцоотой нийт эрэлтийг нэмэгдүүлэх ёстой гэж үзсэн
 D. Мөнгө болон банкны талаарх агуу онолч төдийгүй түүнийг хэрэгжүүлэгч юм
 E. Эдийн засгийн салбарт оруулсан хувь нэмрийг үнэлэн 1974 онд түүнд Нобелийн шагнал олгосон


27. Гадаадын компанийг хянах зорилгоор бус харин үнэт цааснаас ногдол ашиг болон үнэт цаасны ханшийн өсөлтөөс орлого олохын тулд хийдэг үйл ажиллагаа бөгөөд, урт хугацаанд илүү найдвартай байж чадах давуу талтай үйл ажиллагааг.....гэнэ. /1 оноо/

- A. Портфелийн хөрөнгө оруулалт
 B. Гадаадын шууд хөрөнгө оруулалт
 C. Үндэстэн дамнасан корпорац
 D. Олон улсын худалдаа
 E. Гадаад худалдааны бодлого
28. Олон улсын эдийн засагт улс орнуудын эзлэх байр суурийг хэд хэдэн шалгуураар тодорхойлдог. Уг шалгуур үзүүлэлтэд нийцэхгүй өгөгдлийг олно уу? /1 оноо/
- A. Эдийн засгийн хөгжлийн түвшин
 B. Эдийн засгийн бүтэц
 C. Эдийн засгийн бүсүүдийн орлогын хэмжээ
 D. Гадаад эдийн засгийн хэлбэр
 E. Эдийн засгийн өсөлтийн төрөл

29. Иргэд сонгуульд саналаа өгөх, нэрээ дэвшүүлэх, сонирхлын бүлэгтэй хамтран ажиллах, жагсаал цуглаан хийх, төрийн байгууллага, албан тушаалтанд хандан захидал бичих, санал хүсэлт тавих зэрэг олон хэлбэрээр хэрэгждэг. Энэ нь ардчиллын аль үнэт зүйлсийг илэрхийлж байна вэ? /1 оноо/

- A. Олон намын тогтолцоо
 B. Иргэдийн улс төрийн оролцоо
 C. Тэгш эрх
 D. Хуулийн засаглал
 E. Нийтэд тайлагнах, ил тод байх ёс

30. Монгол улсын төрийн эрх мэдэл хуваарилалтын тогтолцоог харуулсан бүдүүвчийг ажиглаад тохирох хариултыг нөхнө үү. /1 оноо/



- A. Тагнуулын ерөнхий газар
 B. Ерөнхий сайд
 C. Улсын их хурлын дарга
 D. Үндсэн хуулийн цэц
 E. Цагдаагийн ерөнхий газар
31. "Иргэний нийгэм нь төрөөс үл хамаарах өөр хоорондын харилцаа, эрх зүйгээр зохицуулагддаг хувь хүмүүс, анги бүлэг, институтуудын нийлбэр цогц" юм. Иргэний нийгмийн тухай тодорхойлсон сэтгэгчдээс хэний үзэл санаа хэлсэн үг вэ? /1 оноо/
- A. К.Поппер
 B. Р.Путнам
 C. Р. Дарендорф
 D. Аристотель
 E. Г. Гегель

32. Иргэний нийгмийн төлөвшил оюун санааны хүрээнд ямар үйл ажиллагаагаар илрэн явагддаг вэ? /1 оноо/

- A. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн бие даасан байдлыг дэмжих
 B. Олон намын тогтолцоо бүхий ардчилсан сонгуулийн систем бүрэлдэх
 C. Хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, үүрэг хариуцлагыг адил тэгш эдлүүлэх
 D. Иргэд хувийн өмчтэй байж, өмчийн олон хэлбэрүүд эрх тэгш хөгжих
 E. Эрх мэдлийг зохистой тэнцвэржүүлэн хуваарилж хуулиар баталгаажуулах

33. Ардчилсан сонгуулийн саналыг шууд өгөх зарчмыг олно уу. /1 оноо/

- A. Сонгогч бүр ижил тооны санал гаргах, санал бүр адил жинтэй байх
 B. Нас хүйс, яс үндэс, мэргэжил, үзэл бодлоос үл шалтгаалан оролцох
 C. Сонгогч зөвхөн өөрийн сонголтоор саналаа өгөх боломжтой байх
 D. Сонгуулийн эцсийн үр дүн нь зөвхөн иргэдийн санал хураалтаар шийдэгдэх
 E. Чөлөөтэй сонголт хийн саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжтой байх


34. 2000 оны Улсын Их Хурлын сонгуульд МАХН /одоогийн МАН/ сонгогчдын 52%-ийн санал авсан ч парламентын суудлын 94.7% буюу 72-ыг авсан бол бусад нам эвслүүд нийт сонгогчдын 48%-ийн санал авсан хэдий ч парламентад дөнгөж 4 суудал авч байжээ. Энэ баримт сонгуулийн аль тогтолцооны сул талыг харуулж байна вэ? /2 оноо/

- A. Пропорциональ тогтолцоо
 B. Мажоритари тогтолцооны энгийн олонх
 C. Мажоритари тогтолцооны харьцангуй олонх
 D. Мажоритари тогтолцооны үнэмлэхүй олонх
 E. Холимог тогтолцоо

35. Байгаль, нийгмийн олон хүчин зүйлээр нөхцөлдсөн, тэгш бус байдлыг арилгаж нийгмийн хамгааллаар хангахад илүү чиглэсэн эдийн засаг дахь төрийн зохистой оролцоог дэмждэг улс төрийн үзэл баримтлал аль нь вэ? /1 оноо/

- A. Консерватизм
 B. Социал демократ
 C. Либерал ардчилал
 D. Неолиберализм
 E. Неоконсерватизм

36. Улс төрийн намын үзэл баримтлалыг шугамд өгч тэмдэглэсэн байна. Тохирох үзэл баримтлалыг сонгож нөхнө үү? /1 оноо/



37. Ардчилсан нийгэмд иргэдэд мэдээлэл олгох, өөрийн гэсэн санаа бодол төлөвшүүлэхэд оролцон туслах, хяналт шалгалт хийх, шүүмжлэл өрнүүлэх, цэнгээн баясгах, боловсрол олгох зэрэг нь хэвлэл мэдээллийнюм. /Нөхөх ойлголтыг сонгоно уу?/ /1 оноо/

- A. Зорилтууд
 B. Үндсэн зарчим
 C. Эрх чөлөө
 D. Эрх ашиг
 E. Үндсэн үүрэг

38. 2016 оны судалгаагаар иргэдийн хэвлэл мэдээллийн байгууллагад итгэх итгэл Монголын үндэсний телевизэд 90%, хувийн телевизэд 78%, FM-радиод 60% гэсэн үнэлгээ өгчээ.

Дээрх эх сурвалж ямар асуудлын тухай мэдээлэл вэ? /1 оноо/

- A. Хэвлэл мэдээллийн байгууллагад иргэдээс өгсөн итгэх итгэлийн судалгаа
 B. Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн бодол
 C. Хэвлэл мэдээллийн байгууллагын талаар хэвлэл мэдээллийн ажилтнуудын өгсөн судалгаанд хийсэн дүгнэлт
 D. Хэвлэл мэдээллийн байгууллагад төрийн байгууллагуудын хандах байдал
 E. Хэвлэл мэдээллийн байгууллагад төрийн бус байгууллагуудын хандах байдал

39. "Хүний үндсэн эрх, хувь хүний нэр төрд итгэх итгэлийг дахин батлах.." гэсэн үндсэн зорилготой анх байгуулагдсан байгууллага аль нь вэ? /2 оноо/

- A. Хүний эрхийн үндэсний комисс
 B. Үндэстнүүдийн лиг
 C. Нэгдсэн Үндэсний байгууллага
 D. Олон Улсын Улаан Загалмайн Нийгэмлэг
 E. Эмнэсти Интернэйшнл

40. "Хүний эрхийн" тухай дараах өгөгдөлийг зөв тохируулна уу. /1 оноо/

a	Малала Юсуфзай	1	"Миний дөрвөн хүүхэд нэгэн өдөр арьсны өнгөөрөө бус, өөрийн чадвар, чадлаараа үнэлэгдэх тийм улсад амьдраасай"
b	Мартин Лютер Кинг	2	Хүний эрх энгийн зүйлээс эхэлдэг
c	Элеанор Рузвельт	3	Нэг хүүхэд, нэг үзэг, нэг ном дэлхийг өөрчилж чадна

- A. a3, b2, c1 B. a1, b3, c2 C. a1, b2, c3
 D. a3, b1, c2 E. a2, b3, c1

41. Иргэд болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь болон нас барахад асрамжид байсан хүмүүст тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн харилцааг нэрлэнэ үү. /2 оноо/

- A. Тэтгэмж B. Нийгмийн халамж
 C. Тэтгэвэр D. Нийгмийн хамгаалал E. Нийгмийн даатгал

42. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч, мөн сайн дураар даатгуулсан эх жирэмслэх, хүүхэд төрүүлэх тохиолдолд нийгмийн даатгалын тэтгэмж авна. Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж олох нөхцөлийг олно уу? /2 оноо/

- A. Нийгмийн даатгалын шимтгэлийг 9 сар, түүний сүүлийн 4 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
 B. Нийгмийн даатгалын шимтгэлийг 12 сар, түүний сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
 C. Нийгмийн даатгалын шимтгэлийг 9 сар, түүний сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
 D. Нийгмийн даатгалын шимтгэлийг 12 сар, түүний сүүлийн 8 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
 E. Нийгмийн даатгалын шимтгэлийг 18 сар, түүний сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
43. Эрх зүйд захирагдах ёсны дагуу орчин цагийн үндсэн хуульд удирдлага болгодог зарчмуудаас хамааралгүй ойлголтыг олно уу. /2 оноо/

- A. Иргэний нийгмийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх B. Хүний эрхийг баталгаажуулах
 C. Эрх зүйт төрийн үндсийг бэхжүүлэх D. Социалист төрийг бэхжүүлэх
 E. Засаг, төрийн эрх мэдлийг хуваарилах

44. Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргахдаа бүрдүүлэх шаардлагатай нэхэмжлэлийн бүрдүүлбэрүүдээс хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/

- A. Нэхэмжлэлийн үнэ буюу хэдэн төгрөг нэхэмжилж байгаа талаар бичих
 B. Нэхэмжлэлийг ямар шүүхэд гаргаж байгаа
 C. Эрх зөрчигчийн буюу хэргийн хариуцагчийн овог, эцгийн нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг
 D. Улсын тэмдэгтийн хураамж буюу шүүхээс үйлчилгээ үзүүлсний хөлсийг хуульд заасан хэмжээгээр төлсөн баримт
 E. Нэхэмжлэгчийн гэр бүлийн байдал, боловсролын түвшин

45. Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь сэргээх, хохирлыг арилгах бүтэц тогтолцоог бий болгох, боловсронгуй хууль тогтоомж батлах нь төрийн ямар үүрэгт орох вэ? /2 оноо/

- A. Хангах үүрэг B. Хүндэтгэх үүрэг C. Хамгаалах үүрэг

D. Ахиц дэвшил гаргах үүрэг E. Нөлөөлөх үүрэг

46. Захиргааны байгууллагын хууль бус актын улмаас эрх зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд нь дээд шатны захиргааны байгууллагын гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн бол захиргааны хэргийн шүүхэд хэд хоногийн дотор нэхэмжлэл гаргах вэ? /1 оноо/

- A. 7 хоног B. 14 хоног
 C. 45 хоног D. 30 хоног E. 60 хоног

47. Баянгол дүүргийн Засаг дарга 2017 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 59 дүгээр захирамжаар иргэн Б-д, мөн оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 274 дүгээр захирамжаар иргэн Г-д газар олгохдоо иргэн Б-ийн нэр дээр байдаг "Очир" дэлгүүрийн газартай давхцал бүхий хэсгийг давхардуулан олгосон байна. Дээрх тохиолдолд иргэн Б эрх зөрчигдсөн гэж үзэн дээд шатны байгууллагад гомдол гаргажээ. Баянгол дүүргийн засаг дарга аль субьектэд хамаарах вэ? /2 оноо/

- A. Гомдол гаргаж буй иргэн B. Хуулийн этгээд
 C. Хариуцагч D. Бусад оролцогч
 E. Гуравдагч этгээд

48. Дэлхийн улс ба улс бус оролцогчид хоорондын олон талт харилцаа, тэдний гадаад бодлого, үйл ажиллагааг судалдаг нийгмийн шинжлэх ухааны салбар аль нь вэ? /1 оноо/

- A. Олон улсын эрх зүй B. Орон судлал
 C. Улс төр судлал D. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй
 E. Олон улсын харилцаа

49. Монгол улс бусад улсын улс төр, эдийн засаг, соёлын хүч чадавхи, үйл ажиллагааг өөрийн боломжоор хянах үнэлэх явдлыг илэрхийлэх ойлголтыг олно уу? /2 оноо/

- A. ОУХ-ны оролцох үүрэг B. ОУХ-нд оролцох нөлөө
 C. ОУХ-нд оролцох үйл ажиллагааны чиглэл D. ОУХ-нд тэргүүлэх чиглэл
 E. ОУХ-нд оролцох зарчим

50. 2011 оны МУ-ын гадаад бодлогын үзэл баримтлал баримт бичгийн /6 дугаар зүйлээс/ гадаадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах бодлогоос үл тохирох өгөгдлийг олно уу? /2 оноо/

- A. Гадаадад зорчиж байгаа иргэдийг хар тамхи, хүний наймаа зэрэг гэмт хэргээс сэрэмжлүүлэх, хэрэгт холбогдож хохирогсдын эрхийг хамгаалах.
 B. Монгол улсаас гадаад улсад суугаа өөрийн иргэн хуулийн этгээдийн эрх ашгийг үндэсний болон тухайн улсын хууль олон улсын гэрээний хүрээнд хамгаалах.
 C. Монгол улсаас гадаад улсад суугаа өөрийн иргэдийнхээ бүртгэл, судалгааг хөтөлж, тэдэнд шаардлагатай үед туслалцаа, дэмжлэг үзүүлэх.
 D. Гадаад улсад суугаа өөрийн иргэдийн үүсгэл санаачилгын байгууллага, холбоодтой хамтран ажиллахдаа тодорхой шалгуур тавих.
 E. Гадаадад байгаа иргэддээ хууль ёсны эрх, үүрэг хариуцлагын талаарх шаардлагатай мэдээлэл зөвлөгөө өгөх.

51. Эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах тогтвортой хөгжлийн загварыг бий болгох, мөн хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулсан ойлголтыг юу гэж үзэх вэ? /2 оноо/

- A. Эдийн засгийн аюулгүй байдал B. Эдийн засгийн олон тулгуурт бүтэц
 C. Гадаад худалдаа, хөрөнгө оруулалт D. Олон улсын тээвэр, дэд бүтэц
 E. Эдийн засгийн бие даасан байдал

52. Улс орны асуудалд түлхүү анхаардаг, улс орнуудад илүү нээлттэй, байгууллагын бүтэцтэй, гишүүн улс орнуудын эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах чиглэлд түлхүү анхаардаг олон улсын харилцааны улс бус оролцогч аль нь вэ? /1 оноо/

- A. Үндэстэн дамнасан корпорацууд
B. Олон улсын төрийн бус байгууллага
C. Олон улсын байгууллага
D. Олон улсын хэвлэл мэдээллийн сүлжээ
E. Олон улсын гэмт хэргийн сүлжээ

53. Доорх ойлголтуудыг харгалзах утгатай нь зөв тохируулна уу. /1 оноо/

a	Үндэстэн дамнасан корпораци	1	Аль Кайда
b	Олон улсын байгууллага	2	Apple, Google
c	Террорист байгууллага	3	НҮБ

- A. a2, b1, c3
B. a2, b3, c1
C. a3, b2, c1
D. a3, b1, c2
E. a1, b2, c3

54. Монгол улс 2011 оны 7 дугаар сараас 2 жилийн хугацаатай даргалан ажилласан олон улсын байгууллага аль нь вэ? /1 оноо/

- A. Олон улсын худалдааны эрх зүйн комисс
B. Ерөнхий Ассамблейн 63 дугаар чуулган
C. Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг /АОХН/
D. ЮНЕСКО-гийн гүйцэтгэх зөвлөл
E. Олон улсын атомын энергийн агентлаг

55. Монгол улс, Бүгд найрамдах Солонгос улс нь олон зуун жилийн харилцааны түүхтэй Азийн орнууд юм. 1990 онд орчин үеийн дипломат харилцаагаа тогтоож хоёр улсын харилцаа эрчимтэй хөгжсөн бол түншлэлийн харилцаа ямар түвшинд хүрсэн бэ? /2 оноо/

- A. Иж бүрэн түншлэл
B. Иж бүрэн стратегийн түншлэл
C. Стратегийн түншлэл
D. Өргөн хүрээтэй түншлэл
E. Олон талт хамтын ажиллагааны түншлэл

56. Зөөлөн хүчний бодлого нь хатуу хүчний бодлогоос зарчмын ялгаа, үйлдлийн төрөл, өндөр хамааралтай хүчний үндэс зэргээрээ ялгаатай байдаг. Тэгвэл зөөлөн хүчний бодлогын зарчим аль вэ? /1 оноо/

- A. Үнэт зүйлс соёл, төрийн бодлог
B. Зорилгыг өөрчлөн чиглүүлэх
C. Сэтгэл татам байдал
D. Үнэмшил тогтолцоо
E. Сэтгэл татах чадвар

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай нийт 20 оноотой.

Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.

2.1 Хүний эрхийг хамгаалах үндэсний болон олон улсын байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлүүдийг зөв харгалзуулна уу. /5 оноо/

a	Улсын Их Хурал	1	Хүний эрх эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих, хамгаалах, дэмжих, төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэгтэй
b	Засгийн газар	2	Хууль тогтоох замаар хүний эрхийг хангах бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх, засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих

c	Шүүх	3	Хүний эрхийг хангах, хамгаалах олон улсын тогтолцоог бүрдүүлэн ажиллах чиг үүргийг гүйцэтгэдэг
d	Хүний эрхийн үндэсний комисс	4	Хүний эрхийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээний биелэлтийг хангах, үр дүнг УИХ, НҮБ-д тогтмол тайлагнах
e	НҮБ	5	Хүний эрх зөрчсөн тухай нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх

2.2 Инфляцид холбогдох ойлголтуудыг зөв харгалзуулна уу. /5 оноо/

a	Эрэлтээс үүдэлтэй инфляци	1	Үйлдвэрлэлийн нөөцийн үнэ өссөнөөр уг бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ дагаж өсөх үзэгдэл
b	Зардлаас үүдэлтэй инфляци	2	Тухайн улсын эдийн засагт инфляцийн үзүүлэх нөлөө бага, түвшин нэг оронтой тоонд багтах үзэгдэл
c	Мөлхөө инфляци	3	Үнэ огцом түргэн бөгөөд жигд бусаар өсөх үзэгдэл. Тухайлбал инфляци 54.2 %-д хүрсэн
d	Цогио инфляци	4	Гүйлгээнд их хэмжээний мөнгө буй болсноос их хэмжээний мөнгө бага хэмжээний бүтээгдэхүүн, үйлчилгээнд ногдох болсноор уг бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн дүн өсөх үзэгдэл
e	Гипер инфляци	5	Тухайн улсын эдийн засагт өндөр хурдтай инфляци бий болж нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө асар их, түвшин нь олон оронтой тоонд хүрэх үзэгдэл

2.3 Дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу. /5оноо/

a	Ухаалаг хүчний бодлого	1	Их гүрнүүд цэрэг, эдийн засгийн хүч чадавхдаа тулгуурлан хүчээр түрий барих бодлого хэрэгжүүлэхийг хэлнэ
b	Хатуу хүч	2	Ёс суртахууныг эрхэмлэн ямар ч үед аль ч нөхцөлд ядарч зүдэрсэн эмзэг бүлгийн хүмүүсийн эрх ашгийг дээдэлж, тэдний ашиг сонирхлыг хүндэтгэсэн үйл ажиллагаа явуулахыг шийдвэр гаргагчид болон манлайлагчдад уриалах, ятган үнэмшүүлэх явдал
c	Зөөлөн хүч	3	Хоёр болон олон талт үйл ажиллагаанд тулгуурлан улс орныхоо худалдаа, болон санхүүгийн ашиг сонирхлыг дипломат аргаар хангах явдал
d	Хүмүүнлэгийн дипломат ажиллагаа	4	Албадлага, урамшууллаар бус харин бусад улсын сэтгэлийг өөртөө татах замаар өөрийн хүсч буй үр дүнд хүрэхийн тулд бусдад нөлөөлөх чадвар
e	Эдийн засгийн дипломат ажиллагаа	5	Улс өөрийн үндэсний ашиг сонирхол, гадаад бодлогын зорилгоо хэрэгжүүлэхдээ өөрт байгаа улс төр, стратеги, эдийн засаг, соёл зэрэг бүх арга хэрэгсэлээ тэнцвэртэй хоршуулах чадвар

2.4 Соёлын аялал жуулчлалын зарчим, төрлүүдийг ойлголтуудтай зөв харгалзуулна уу.

/5 оноо/

a	Орон нутгийн хүн амын амьжиргаа, нийгэм эдийн засгийн хөгжилд үр ашгаа өгөх	1	Олон улсын харилцаа, харилцан хүндэтгэл, ойлголцол, энх тайвнаар зэрэгцэн орших зорилгод зэрэгээр нөлөөлнө
b	Байгалийн болон соёлын өвийн газруудтай харилцан шүтэлцээтэй хөгжүүлэх	2	Хөдөө орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлснээр хот руу чиглэх хүн амын урсгалыг багасгадаг
c	Байгалийн болон соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг бэхжүүлэх	3	Хөвсгөл нуур болон цаатангуудын соёлын өвүүдийг харилцан хамааралтай, хослуулан авч үзэх
d	Соёлын солилцоонд тулгуурлах	4	Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас иргэд гадагш гэхээсээ илүү орон нутаг дахь байгаль, түүх соёлын дурсгалт газруудаар аялах байдал нэмэгдсэн
e	Дотоодын аялал жуулчлал	5	Хөшөө цайдамын "Түрэгийн хүн чулууны түүхэн дурсгалт" газрыг Турк улсын дэмжлэгтэйгээр сэргээн засварласан

№	C	D	Оноо
1	B	A	1
2	D	C	2
3	C	B	2
4	E	D	2
5	D	E	1
6	A	E	2
7	D	D	1
8	C	C	1
9	C	D	2
10	C	C	2
11	E	D	1
12	E	C	1
13	D	B	2
14	D	B	1
15	A	E	2
16	A	E	1
17	B	A	2
18	B	A	1
19	D	C	2
20	A	D	1
21	C	E	1
22	E	A	2
23	B	C	1
24	C	B	1
25	A	D	2
26	D	E	2
27	E	A	1
28	D	C	1
29	C	B	1
30	B	D	1
31	C	E	1
32	A	A	1
33	E	D	1
34	D	C	2
35	C	B	1

36	B	D	1
37	D	E	1
38	E	A	1
39	A	C	2
40	D	D	1
41	C	E	2
42	B	B	2
43	D	D	2
44	E	E	1
45	A	A	2
46	D	D	1
47	C	C	2
48	B	E	1
49	D	B	2
50	E	D	2
51	A	A	2
52	D	C	1
53	C	B	1
54	B	C	1
55	E	A	2
56	E	E	1
2.1	a3	a2	1
	b5	b4	1
	c4	c5	1
	d1	d1	1
	e2	e3	1
2.2	a4	a4	1
	b3	b1	1
	c1	c2	1
	d5	d3	1
	e2	e5	1
2.3	a4	a5	1
	b5	b1	1
	c3	c4	1
	d2	d2	1
	e1	e3	1
2.4	a4	a2	1
	b1	b3	1
	c2	c5	1
	d3	d1	1
	e5	e4	1